

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 4 дүгээр сарын 15

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 03 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2013-02сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2013-03 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	213	11 ¹	5 ²	219
3	Даатгалын төлөөлөгч	2391	47 ³		2438
4	Даатгалын зуучлагч	17	1 ⁴		18
5	Даатгалын хохирол үнэлэгч	10			10
6	Актуарч	15			15
7	Бусад	15	1 ⁵		16

¹Хорооны даргын 2013 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 60 дугаар тушаалаар “Хаан даатгал” ХХК-ийн 11 даатгалын салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөх шийдвэр гаргасан байна.

²Хорооны даргын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 74 дүгээр тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн салбар, “Соёмбо даатгал” ХХК-ийн Завхан, Ховд аймгийн салбар, “Монре даатгал” ХХК-ийн Дорноговь аймгийн салбар, “Тэнгэр даатгал” ХХК-ийн Дундговь аймгийн салбаруудыг тус тус үчингүй болгосон байна.

³Хорооны даргын 2013 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 6 иргэнд, 2013 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 73 дугаар тушаалаар “Бодь даатгал” ХХК-ийн 10 иргэнд, 2013 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 75 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 19 иргэнд, “Монре даатгал” ХХК-ийн 12 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

⁴Хорооны 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 92 дугаар тогтоолоор “Эс Ай Би Эс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

⁵Хорооны 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 91 дүгээр тушаалаар “Хаан даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 03 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд болон өссөн дүнгээр харуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.03.31 /сарын дүн/	2013.03.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	7,582,088,695.91	14,617,442,512.95
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	761,587,558.33	1,573,092,032.08
Олгосон нийт нөхөн төлбөр	2,094,293,086.35	6,596,232,054.86
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	777,809,815.00	2,864,692,900.80
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1,648.00	5,782.00
Давхар даатгалд төлсөн хураамж	4,133,668,362.86	5,304,905,328.20
Байгуулсан даатгалын гэрээний тоо	23,156.00	55,414.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	12,049.00	30,027.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	13,847.00	33,027.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	35,491,153,200.00	139,261,000,000.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	71,368,723.00	2,765,702,746.49

2013 оны 03 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 14617.4 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 1573.1 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 6596.2 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 2864.7 сая төгрөг болсон байна. Эндээс хохирол өхөлтийн түвшин сарын байдлаар 27.6 хувь, өссөн дүнгээр 45.1 хувь болсон бөгөөд 1 дүгээр улирлын байдлаарх үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 15.1 пунктээр нэмэгдсэн байгаа нь жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
	2013.03.31 /сарын дүн/	2013.03.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	113,526,878.00	230,879,186.00
Олгосон нийт нөхөн төлбөр	7,677,647.00	23,391,606.00
Давхар даатгалд төлсөн хураамж	353,508.00	1,771,054.00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	19.00	59.00
Хувь хүний хугацаат даатгалд	3.00	6.00
Байгууллагын хугацаат даатгалд	1.00	6.00
Өндөр хамгаалалттай ЭМД-д	2.00	2.00
Эмнэлгийн мөнгөний даатгалд	5.00	14.00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	1.00	9.00
Тэтгэврийн даатгалд	3.00	13.00
Орон сууцны даатгалд		2.00
Хуримтлалын даатгалд		3.00
Зээлдэгчийн амь насны даатгалд	4.00	9.00

Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1,400,000,000.00	1,400,000,000.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	1,833,943.00	5000,000

Урт хугацааны даатгагч 2013 оны 03 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 230.8 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 23.4 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Өмнөх оны мөн үеийн 3 дугаар сарын дүнтэй харьцуулбал хураамжийн орлого 50.6 сая төгрөгөөр өсч, нөхөн төлбөр 1.1 сая төгрөгөөр буурчээ.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.03.31 /сарын дүн/	2013.03.31 /өссөн дүн/
Нийт орлого	19,054,708.66	71,660,776.53
Даатгалын зуучлагчийн орлого	22,251,105.06	70,615,611.58
Үүнээс: Сайн дурын даатгал	14,343,561.46	61,864,376.43
Албан журмын даатгал	2,427,097.20	3,270,788.75
Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	35,592,406.00	98,805,511.04
Зуучилсан даатгалын гэрээний тоо	612.00	701.00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	7,029,050,000.00	31,929,161,910.00

2013 оны 03 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 70.6 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 87.6 хувийг сайн дурын даатгалаафүлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК-ийн зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Лоялти солюшн” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК, ХХК, “Нэйшнл эженси” ХХК “Хасбанк” ХХК-иуд тус тус 03 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2012.03.31 /сарын дүн/	2012.03.31 /өссөн дүн/
Нийт орлого	53,656,300.00	93,708,255.00
Даатгалын хохирол үнэлгээний орлого	7,572,149.00	27,312,740.00
Үүнээс: Сайн дурын даатгал	3,126,318.73	10,952,227.73
Албан журмын даатгал	4,445,830.27	16,360,511.27
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	918.00	2,491.00

2013 оны 03 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохиролүнэлэгч компаниуд 93.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 40 хувийг сайн дурын, 60 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Мега марз” ХХК, “Гэрэгэ эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК-иуд тус тус 03 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 93 дугаар тогтоолоор “Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан журам”-д өөрчлөлт орсон. Хорооны 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 102 дугаар тогтоолоор “Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан журам”-д нэмэлтөөрчлөлт орсон бөгөөд 104 дүгээр тогтоолоор “Номин даатгал” ХХК-ийн ахлах нягтлан бодогчоор Чулуунбат овогтой Оюунгэрэлийг томилохыг зөвшөөрсөн байна.

Хорооны даргын 2013 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 70 дугаар тушаалаар “Юу ай би” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 71 дүгээр тушаалаар “Ачит ундарга” ХХК-ийн Дорноговь аймагт салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөх тухай, 72 дугаар тушаалаар “Аме” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай тус тус шийдвэрүүд гарсан байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

2013.04.16